



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 02 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар ХЭРГ 451

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.АЮУРСАЙХАН ТАНАА

Асуултын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааны өмчлөлтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуултын хариуг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: 2 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0002048

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Т.АЮУРСАЙХАН, Ж.БАТЗАНДАН,
Л.БОЛД, Х.НЯМБААТАР НАРААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛТЫН ХАРИУ

Асуулт: Улсын Их Хурлын тогтоолыг зөрчиж, Улсын бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагын зүгээс өмчлөлийг шилжүүлэхгүй байх болон үүсч байж болзошгүй бусад нөхцөл байдлын талаар:

Хариулт: Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр 5801621 регистрийн дугаар, 9011461093 бүртгэлийн дугаартай, 112.001.000.000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй “Монголиан коппер корпорейшн” ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч Ц.Пүрэвтүвшингээс тус компанийн нийт хувьцааг Сингапур улсад бүртгэлтэй “Эрдэнэт Корп Пти.Лтд” компани /мөн Ц.Пүрэвтүвшингийн эзэмшлийн/-д 100 хувь шилжүүлж, гадаадын хөрөнгө оруулалттай компани болохыг бүртгүүлэхээр 88 хуудас баримт бичгийг бүрдүүлж ирүүлжээ.

Тус баримт бичигт хавсаргасан 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 19/01 дугаар бүхий Хувьцаа худалдах болон эрх шилжүүлэх гэрээний 1.1-д нийт хувьцааг 112.001.000.000 төгрөг буюу 41.999.535 ам.доллараар худалдахаар, 5.1-д талууд гэрээнд гарын үсэг зурсны дараа худалдан авагч тал гэрээний урьдчилгаа төлбөр болох 110.000 ам долларыг төлөхөөр, үлдэгдэл төлбөрийг худалдан авагч тал санхүүгийн тайландаа дараа төлөх үүргээр бүртгэн тэмдэглэхээр тус тус заасан.

Уг гэрээний дагуу Сингапур улсад бүртгэлтэй “Эрдэнэт Корп Пти.Лтд” компани нь урьдчилгаа төлбөрийг Ц.Пүрэвтүвшингийн хувийн дансанд 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр 80.362.54 SGD, 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 50.000 ам доллар шилжүүлсэн тухай банкны тодорхойлолт, дансны хуулгыг хавсаргасан.

Эдгээр баримт бичиг нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.1-д “хөрөнгө оруулалт гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг хэлнэ.” гэж, 3.1 5-д “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг хэлнэ.” гэж тус тус заасан шаардлагуудыг хангаагүй буюу “Монголиан коппер корпорейшн” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт ороогүй болно.

Мөн бүрдүүлсэн баримт бичигт Сингапур улсын “Эрдэнэт Корп Пти.Лтд” компанийн гэрчилгээ, дүрмийг хавсаргасан боловч уг дүрмийн монгол хэлнээ орчуулсан баталгаат орчуулга хийгдээгүй нь Монгол хэлний тухай хуулийн 4.1.1-д “төрийн албан ёсны хэл гэж төрийн байгууллага, хуулийн этгээдийн аливаа үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөх орчин цагийн утга зохиолын монгол хэлийг хэлнэ.” гэж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.4-т “энэ хуулийн 16.1, 16.2, 16.3-т заасан баримт бичиг нь гадаад хэлээр үйлдэгдсэн бол мснгол хэлнээ орчуулж, хавсаргана.” гэж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын 3.3-т “Өргөдөлд хавсаргасан баримт бичиг гадаад хэлээр үйлдэгдсэн бол монгол хэлнээ орчуулж, баталгаажуулсан хувийг

хавсаргана.” гэж тус тус заасныг зөрчсөн.

Иймд хуульд заасан журмын дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэгч 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэр гаргаж, ирүүлсэн баримт бичгийг өргөдөл гаргагчид буцаасан байна.

2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар “Монголиан коппер корпорейшн” ХХК-аас улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт дахин ирүүлээгүй байна.

Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн статусыг өөрчлөх, дүрмийг батлах, холбогдох бүртгэлийг Улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг арга хэмжээг төрийн эрх бүхий байгууллагаас тухай бүрд нь авч хэрэгжүүлсэн бөгөөд одоогийн байдлаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК нь 100% төрийн өмчит хуулийн этгээд хэлбэрээр Улсын бүртгэлийн мэдээллийн санд байгаа болно. Улсын бүртгэлийн энэ бүртгэл өөрчлөгдөөгүй байна. <http://opendata.burtgel.gov.mn/>

oooOooo